



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Эрүүл, спортлог Чингэлтэй-2028”
арга хэмжээ батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн анхан болон лавлагaa шатлалын тусlamж үйлчилгээг стандартын шаардлагад нийцсэн орчин нөхцөлд түргэн шуурхай хүргэх, нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг иргэд, олон нийт, хамт олны идэвх оролцоотойгоор нэмэгдүүлж, иргэдийг хөдөлгөөний хомсдолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28.-ны
өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт

“ЭРҮҮЛ, СПОРТЛОГ ЧИНГЭЛТЭЙЧҮҮД-2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай 19 дүгээр тогтоолоор Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэх зорилтыг хөгжлийн бусад зорилтуудын хамт дэвшүүлж, 2021-2025, 2026-2030 онуудад хүрэх түвшнийг тодорхойлсон бөгөөд Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” арга хэмжээний хүрээнд эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлж, эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлэх зорилтыг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Арга хэмжээний 1 дүгээр үе шат болох 2020-2030 онуудад Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе хэмээн тодорхойлсон. Үүнд:

1. Иргэн, гэр бүл ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний үндэсний тогтолцоог бүрдүүлэх

2. Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх

3. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх

4. Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар нийгмийн хамгааллыг сайжруулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр зорилт төлөвлөгөө гаргасан.

Чингэлтэй дүүргийн нийт хүн амд нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан болон эмнэлгийн лавлагаат шатлалын тусlamж үйлчилгээг дүүргийн 1-24 дүгээр хороодын харьяа 16 Өрхийн эрүүл мэндийн төв, Нарийн мэргэжлийн Төв салбар, Бага тойруу салбар, Хайлааст хүүхдийн салбар нийт 3 амбулатори, хэвтэн эмчлүүлэх 252 ортой нэгдсэн эмнэлгээр дамжуулан хүргэж, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн салбарын бодлого, чиглэлийг баримтлан эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлж байна.

2024 оны жилийн эцсийн статистик мэдээллээр хүн амын өвчлөл нас бааралтын тэргүүлэх шалтгаанд:

- a) Хорт хавдар 23%
- b) Зүрх судасны өвчлөл 22%
- c) Санамсаргүй хордох, хорт бодист өртөх 12%
- d) Осол гэмтэл 8%
- e) Тархины цус харвалт 6% тус тус эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд хүн амын өсөлтийн түвшин 2024 онд өмнөх оны дундажтай харьцуулахад харьцангуй буурч, жилд дунджаар 4.8% буурсан үзүүлэлттэй байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар жирэмсний эрт хяналт 89.3%, амьгүй төрөлт 12/6.8 промилль, гэрийн төрөлт 8/0.5%, хяналтгүй төрөлт 16/0.92%, төрөлхийн тэмбүү өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. 1000 амьд төрөлтөнд ногдох 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 6 тохиолдол буюу 1000 амьд төрөлтөнд промилль бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.4 промиллиэр өсч, нийслэлийн дунджаас 0.7 промиллиэр дээгүүр байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 40%-ийг гадны шалтгаантай осол гэмтэл эзэлж байна. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 18 тохиолдол буюу 1000 амьд төрөлтөд 10.2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 промиллиэр буурсан, нийслэлийн дунджаас 1.9 промиллиэр доогуур үзүүлэлттэй байна. Халдварт өвчний 1100 тохиолдол бүртгэгдсэн нь 10'000 хүн амд 78.42 промилль, бэлгийн замаар дамжих халдварт, сурьеэ, салхин цэцэг, гар, хөл, ам, гэдэсний замын халдварт өвчинүүд тэргүүлэх байрыг өзэлж байна. Халдварт өвчнөөс цочмог халдварт өвчний гаралт буурч байгаа ч бэлгийн замаар дамжих халдварт өсөж, сурьеэгийн өвчлөл буурах хандлагатай байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хурээнд нийт хүн амын 45-60%-ийг эрүүл мэндийн сургалтад хамруулж байгаа боловч иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинд төдийлөн ахиц гарахгүй, эрүүл мэндийн дадал хандлагад өөрчлөлт орохгүй, эрүүл мэндийг дэмжигч орчин бурдүүлэх ажил шаардлагын түвшинд хүрэхгүй байсаар байна.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Эрүүл мэндийн тухай, Биеийн тамир, спортын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газар, нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэнд, нийтийн биеийн тамирын чиглэлийн зорилтуудад үндэслэн дүүргийн "Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд-2028" арга хэмжээг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үсэж байна.

Хоёр.Арга хэмжээний зорилго

Эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг стандартын шаардлагад нийцсэн орчин нөхцөлд, мэргэжлийн багаар чанартай,

тэгш хүртээмжтэйгээр үзүүлэн анхан болон нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг иргэд олон нийт, хамт олны идэвх оролцоотойгоор сайжруулан тусlamж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл бие бялдар, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэхэд арга хэмжээний зорилго оршино.

Гурав.Арга хэмжээний зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна.

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хурээнд:

Бүх наасны иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр:

1.Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

2.Дүүргийн харьяа төр, хувийн хэвшлийн СӨБ, ЕБС-иудад “Шүдээ зөв угаах”, “Гар угаах, амьсгал, хоол хүнс, усаар дамжих халдварт болон халдварт бус өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, аян, арга хэмжээ зохион байгуулна.

3.Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд өдөрлөг, үйл ажиллагаа, аянуудыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангана.

4.Дүүргийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагад ажлын байранд эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээнүүдийг зохион байгуулах, дүүргийн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

5.Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах, нөхөн үржихүйн наасны эмэгтэйчүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт, аян, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.Нийслэлд жишиг болох “Эрүүл мэндийг дэмжигч иргэн, өрх, байгууллага” хөтөлбөрийг боловсруулан хороо, ΘЭМТ-ийг түшиглэн хэрэгжүүлж үр дүн тооцсон байна.

Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн чиглэлээр:

1.Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвартын эрт илрүүлэг, оношилгоог эрчимжүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх, хавьтлын илрүүлэг, эмчилгээг сайжруулах олон талт арга хэмжээг дүүргийн хэмжээнд жил бүр хэрэгжүүлнэ.

2. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, дэгдэлтийн үед шуурхай авах, тархалтыг хязгаарлах, өвчлөл, нас баралтыг бууруулах чиглэлээр олон талт үйл ажиллагааг цаг тухайд нь зохион байгуулж, хөрөнгө, нөөцийг зарцуулна.

3. Дархлаажуулалтын аюулгүй, тасралтгүй байдлыг хангаж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавина.

4. Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт бус болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хүн амыг хамруулах, анхан болон лавлагаа шатлалын байгууллагын мэдээллийн урсгал, уялдаа холбоог сайжруулна.

5. Халдварт болон халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйл, зан үйлийн талаар тандалт, судалгааг өргөжүүлэх, санал зөвлөмж гаргаж хэрэгжүүлнэ.

6. Халдварт бус өвчний эрсдэлтэй буюу таргалалт, жингийн илүүдэлтэй иргэдийг Биеийн тамир, спортын хороотой хамтран эрүүлжүүлэх ажлыг эхлүүлнэ.

7. Халдварт бус өвчний эрт илрүүлэгт шаардагдах тоног төхөөрөмж, түргэвчилсэн оношлуур, дагалдах эмнэлгийн хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

8. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг шинжилгээ, оношилгооны "Хиймэл оюун ухаанд суурилсан" орчин үеийн оношилгооны туршлага судлах, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж нутагшуулна.

Зорилтот насын иргэдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чиглэлээр:

1. Цэргийн насын залуусыг эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.

2. "Эрүүл шүд" арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, шүд, амны хөндийн өвчлөлийг бууруулна.

3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, сэргээн засах, уламжлалт эмчилгээний чиглэлээр хамт олонд тулгуурласан арга хэмжээнүүдийг зохион байгуулах, энэ чиглэлээр сувилахуйн болон гэрээр үзүүлэх тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

Халдварт бус өвчиний шалтгаант нас баралтыг бууруулах чиглэлээр:

Дүүргийн хэмжээнд нас баралтын тэргүүлэх шалгаан болох зүрх судасны өвчин, хорт хавдрыг эрт илрүүлж, эмчлэх, хянах тогтолцоог бий болгож, нас баралтыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.

Хүрэх үр дүн:

- Бүх насны иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлж, эрүүл зан үйл, амьдралын зөв хэв маягийг хэвшүүлнэ.

-Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, хяналтын нэгдсэн мэдээллийн системтэй болж, хяналтын тогтолцоо сайжирсан байна.

-Зорилтот насны иргэдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хүrtээмж, чанар сайжирч, өвчлөл буурсан байна.

-Халдварт бус өвчний шалтгаант нас барагтыг бууруулахад анхан болон лавлагаа шатлалын уялдаа холбоо сайжирч, нийслэлийн хэмжээнд жишиг үйл ажиллагаатай болсон байна.

Зорилт 2.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоод, гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамруулах, туршлага судлах ажлыг зохион байгуулж, сайн туршлагыг нутагшуулснаар эмчилгээ, үйлчилгээний чанарыг сайжруулна.

Зорилт 2-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.Хамтын ажиллагааны хүрээнд олон улсын бусад байгууллагуудтай хамтран эрүүл мэндийн үзлэг, арга хэмжээ зохион байгуулах, нэн шаардлагатай мэргэжлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамруулах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлж, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

2.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг орчин үеийн манлайлал, харилцаа хандлагыг сайжруулах сургалтад хамруулж, эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний чанар стандартыг сайжруулна.

3.Амбулатори, нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа хандлагыг сайжруулж, иргэдийн санал гомдлыг тодорхой хувиар бууруулна.

4.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах чиглэлээр эх барих, эмэгтэйчүүдийн эмч, бага эмч, сувилагч нарыг чадавхжуулах сургалтад хамруулах, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт, аян, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн:

-Гадаад, дотоод хамтын ажиллагаатай байгууллагуудын тоог нэмэгдүүлж олон улсын сайн туршлагыг нутагшуулсан байна.

-Мэргэшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдэж, эрт илрүүлгийн хамралтыг сайжруулсан байна.

-Иргэдийн хүлээгдэл, чирэгдэл 20%-иар буурч, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 90%-д хүрсэн байна.

-Эх, хүүхэдтэй холбоотой эндэгдэл буурч, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, жирэмсэн, төрсний дараах тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

Зорилт 3.Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, спортын олон талт арга хэмжээ зохион байгуулна.

Зорилт 3-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий олон төрөлт уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна.

2. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Θсвөрийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлэн үйл ажиллагааг өргөжүүлэх, бэлтгэл сургуулилтыг чанаржуулах, гадаад, дотоодын уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлж ажиллана.

3. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Θсвөрийн шигшээ баг, 1-24 дүгээр хороодын Спорт хамтлагийн үйл ажиллагааг өргөжүүлэн, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулж, уралдаан тэмцээнд амжилттай оролцох, чансаа ахиулах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

4. Усан спортын боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, багш дасгалжуулагчдыг чадваржуулан, мэргэжлийн баг бүрэлдэхүүнийг бэлтгэнэ.

Хүрэх үр дүн:

-Дүүргийн ахмад, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, оролцогчдын спортоор хичээллэх хүсэл сонирхлыг нэмэгдүүлж, тэднийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлнэ.

-Дүүргийн Засаг даргын дэргэдэх Θсвөрийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулж, уралдаан тэмцээний амжилтын чанарыг ахиулна.

Дөрөв.Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчмууд

Арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтална.

- ✓ Арга хэмжээний зорилго, зорилтууд хууль, эрх зүйн акт, тогтоол, шийдвэрт нийцсэн байх
- ✓ Арга хэмжээний зорилго бодитой, зорилтууд хэрэгжихүйц байх

- ✓ Арга хэмжээний хэрэгжилт нь төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, эрүүл мэнд, спортын мэргэжлийн байгууллага, иргэд, олон нийтийн идэвх санаачилга, тэгш оролцоонд тулгуурласан байх

Тав.Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1.“Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд-2028” арга хэмжээг 2025-2028 он хүртэл нийт 4 жилийн хугацаанд 3 зорилт, 26 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

5.2.Арга хэмжээний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.2.1.Улс, нийслэлийн төсөв

5.2.2.Орон нутгийн төсөв

5.2.3.Олон улсын болон төрийн бус байгууллагын дэмжлэг

5.2.4.Бусад эх үүсвэр

Зургаа.Арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт

6.1.Арга хэмжээний хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн хэмжээнд удирдлага, төлөвлөлт, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, эрүүл мэнд, спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болон иргэд, олон нийтийн дэмжлэг туслалцаа, идэвх оролцоог хангаж ажиллана.

6.3.Арга хэмжээний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол сурталчлан ажиллах ба эрүүл мэнд, спорт, нийтийн биеийн тамирын чиглэлээр сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах чиглэлд анхаарч ажиллана.

Долоо.Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

-Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь оролцогч талуудыг тэгш оролцоог хангаж, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба үр дүнгийн хэрэгжилтийг жил бүр гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд тайлагнана.

-Арга хэмжээний хэрэгжилтийг зорилтын биелэлт, үйл ажиллагааны чиглэлийн үр дүнгээр үнэлнэ.

Арга хэмжээний үр дүн:

-Эрүүл мэндийн тусlamж, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд тэгш хүrtээмжтэй хургэсэн байна.

-Иргэд, олон нийтэд эрүүл мэндийн үйлчилгээ, лавлагаа тусlamж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангасан байна.

-Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаанд иргэдийг тэгш хамруулсан байна.

-Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага дээшилж, үйлчилгээний чанар хүrtээмж дээшилсэн байна.

-Нийтийн биеийн тамираар хичээллэх иргэдийн тоо нэмэгдэж, эрүүл амьдралын дадал хэвшилд суралцсан байна.

Шалгуур үзүүлэлт:

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2024 он | Зорилтот түвшин | | | |
|--|--|-------------|-------------------------|-----------------|---------|---------|---------|
| | | | | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилт 1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэдийн идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшилэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна. | | | | | | | |
| Бүх насны иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр: | | | | | | | |
| 1 | Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ЭМ-ийн сургалт зохион байгуулсан байдал /3.4/ | тоо | 6 | 8 | 10 | 15 | 20 |
| 2 | СӨБ, ЕБС-иудад ЭМ-ийн чиглэлээр сургалт, сурталчилгаа, аян, үйл ажиллагаа зохион байгуулсан байдал /1.2/ | тоо | 11000 | 12000 | 13000 | 14000 | 15000 |
| 3 | Эрүүл мэндийг дэмжиж хөтөлбөр боловсруулсан байдал /3.5.6/ | тоо | 1 | 2 | 2 | 2 | 2 |
| 4 | Халдварт өвчинээс сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэд /3.4/ | тоо | 11000 | 12000 | 13000 | 14000 | 15000 |
| 5 | Халдварт болон Халдварт бус өвчний илрүүлгийн чиглэлээр зохион байгуулсан аян, өдөрлөг /3.4/ | тоо | Аян-1 | 3 | 4 | 4 | 4 |
| Зонхиолон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн чиглэлээр: | | | | | | | |
| 6 | Халдварт өвчний үзүүлэлт /1.2/ | тоо | 1178 | 1200 | 1250 | 1300 | 1350 |
| 7 | Бэлгийн замын халдварт өвчний тохиолдол /7.8/ | хувь | 2.4 | 2,3 | 2,2 | 2,1 | 2 |

| | | | | | | | |
|----|--|------|--------|------|------|------|------|
| 8 | Тэмбүү өвчний тархалтын түвшин /7.8/ | хувь | 9.84 | 9,5 | 9 | 8,5 | 8 |
| 9 | Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүүгийн тархалт /7.8/ | хувь | 2.4% | 2,3% | 2,2% | 2,1% | 2% |
| 10 | Тэмбүү өвчнөөр оношлогдсон жирэмсэн эмэгтэйчүүдийн эмчилгээнд хамрагдсан байдал /7.8/ | хувь | 100 | 100% | 100% | 100% | 100% |
| 11 | Артерийн даралт ихдэх өвчний эрт илрүүлэг /10-14/ | хувь | 63.48% | 68% | 72% | 75% | 78% |
| 12 | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг /10-14/ | хувь | 65.7% | 70% | 75% | 80% | 85% |
| 13 | Дархлаажуулалтын хамрагдалтын түвшин /9/ | хувь | 95% | 96% | 96% | 97% | 97% |
| 14 | Хөхний хавдрын эрт илрүүлэг /10-14/ | хувь | 63.3% | 65% | 68% | 70% | 75% |
| 15 | Умайн хүзүүний эрт илрүүлэг /10-14/ | хувь | 22.5% | 35% | 40% | 50% | 60% |
| 16 | Хиймэл оюун ухаанд сууринсан "Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, шинжилгээ" хийдэг болсон байдал /14/ | тоо | 0 | 100 | 500 | 800 | 1500 |
| 17 | Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг /10-14/ | хувь | 58.7% | 60% | 65% | 70% | 75% |
| 18 | Иргэдийн эрт илрүүлгийн хамралтыг нэмэгдүүлэх /10-14/ | хувь | 39% | 50% | 60% | 70% | 80% |

Зорилтот насны иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр

| | | | | | | | |
|----|--|------|-----------------------|-----|-----|-----|-----|
| 19 | "Эрүүл шүд" арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн /16/ | хувь | 50% | 55% | 60% | 65% | 70% |
| 20 | Цэргийн насны эрүүлжилт /15/ | хувь | 55% | 58% | 60% | 62% | 65% |
| 21 | Гэрийн идэвхтэй эргэлт /17/ | хувь | 15% | 20% | 24% | 28% | 32% |
| 22 | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний нас баралтыг бууруулах /17/ | хувь | 63,3 /10,000 хүн амд/ | 60 | 58 | 56 | 55 |

Зорилт 2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоод, гадаадын урт болон богино хугацааны сургалтад хамруулах, туршилага судлах ажлыг зохион байгуулж, сайн туршилагыг нутагшуулна.

| | | | | | | | |
|----|---|-----|----|----|----|----|----|
| 23 | Мэргэжлийн чиглэлээр гадаадад богино дунд хугацааны сургалтад хамрагдсан байдал /1/ | тоо | 0 | 3 | 5 | 8 | 10 |
| 24 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн бүх талын арга хэмжээ, | тоо | 10 | 15 | 20 | 25 | 30 |

| | | | | | | | |
|---|---|------|-------|--------|--------|--------|--------|
| | хөнгөлөлтийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлсэн байдал/3,4/ | | | | | | |
| 25 | Амбулатори болон нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлсэн иргэдийн хүлээгдэл, сэтгэл ханамж/3,4/ | хувь | 78% | 80% | 82% | 84% | 85% |
| 26 | Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийг нэн шаардлагатай мэргэжлийн чиглэлээр сургаж, мэргэшүүлсэн байдал /1/ | тоо | 3 | 5 | 8 | 10 | 15 |
| 27 | Эхийн эндэгдэл /4/ | хувь | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 28 | Нялхсын эндэгдэл /4/ | хувь | 9.9 | 9,5% | 9% | 8,5% | 8% |
| 29 | 1-5 хүртэлх насны эндэгдэл /4/ | хувь | 2.6 | 2,4 | 2,2 | 2 | 1,8 |
| 30 | 0-1 насны хүүхдийн гэрийн идэвхтэй эргэлт /4/ | хувь | 82% | 85% | 88% | 91% | 94% |
| 31 | Хяналтгүй төрөлт /4/ | хувь | 0.9% | 0,8 | 0,7 | 0,6 | 0,5 |
| 32 | Жирэмсний эрт хяналт /эхний 3 сард/-4 | хувь | 89.5% | 90% | 92% | 93% | 94% |
| Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт: Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, спортын олон талт арга хэмжээ зохион байгуулна. | | | | | | | |
| 33 | Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх уралдаан тэмцээнд хамрагдсан иргэдийн тоо | тоо | 31,0 | 35,0 | 38,0 | 40,0 | 42,0 |
| 34 | Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааны амжилтын тоо | тоо | 474 | 480 | 500 | 520 | 530 |
| | Гадаад, дотоодын уралдаан тэмцээнд гаргасан амжилтын тоо | тоо | 30 | 35 | 40 | 45 | 50 |
| 35 | Фитнес заал, спорт заал, мөсөн гулгуурын талбай, бусад заал талбайгаар үйлчлүүлсэн иргэдийн тоо | тоо | 20,0 | 25,0 | 28,0 | 32,0 | 35,0 |
| 36 | Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хамарсан хөдөлгөөн, хамрагдсан хүний тоо | тоо | 5,000 | 8,000 | 10,000 | 12,000 | 15,000 |
| 37 | Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан албан хаагч, иргэдийн тоо | тоо | 8,000 | 10,000 | 12,500 | 16,000 | 20,000 |
| 38 | Усанд сэлэлтийн сургалтад хамрагдсан ЕБС-ийн сурагчдын тоо | тоо | 2,800 | 3,000 | 3,500 | 4,000 | 4,500 |